Шүдний эмч нарын ажил мэргэжилтэй холбоотой стресс үүсгэгч хүчин зүйлийг судалсан дүн

Г.Сайнзаяа[1], Ч.Батжаргал[1], М.Соёлмаа[1], Ж.Уржинлхам[1]

[1]АШУҮИС, НАСТЭ, Нүүр амны эмчилгээний тэнхим
[2]Коралдент шүдний эмнэлэг
Цахим шуудан: zayags.724@gmail.com, Утас: 99121908

Түлхүүр үг:

Үйлчлүүлэгч
Ажлаас халшрах
Стресс
Цаг хугацаа

Товч утга:

Үндэслэл: Судалгаагаар шүдний эмч нарын талаас илүү хувь нь мэргэжлээс шалтгаалах стресст өртсөнөөс тэдний ажлын бүтээмж буурах төдийгүй амьдралын чанарт ч сөрөгөөр нөлөөлж буй нь батлагджээ.[11] Стрессийн нөлөөнд тогтмол өртсөнөөр хувь хүн оюун санаа, бие махбод, сэтгэлзүйн хувьд ядарч үйлчлүүлэгч, хамтран ажиллагсаддаа сөрөг, хайхрамжгүй хандах, ажилдаа хэт их санаа зовсноос сэтгэл санааны тогтворгүй байдалд орж байгааг тэмдэглэсэн байна. **Зорилго:** Шүдний эмч нарын ажил мэргэжилтэй холбоотой стресс үүсгэх хүчин зүйлсийг тодорхойлох. **Арга, аргачлал:** Аналитик судалгааны агшингийн загвараар Улаанбаатар хотод мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй шүдний эмч нараас санамсаргүй түүврийн аргаар сонгон, ерөнхий мэдээлэл, мэргэжлийн стресс үүсгэгч хүчин зүйлс, стрессийг даван туулах арга, үр нөлөөг үнэлэх 42 асуулт бүхий асуумжыг ашиглан хийж, үр дүнг SPSS-25 программаар боловсруулалт хийв. **Үр дүн:** Энэ судалгаанд 289 шүдний эмч хамрагдсанаас эмэгтэй 222 (77%) нь, эрэгтэй 67 (23%) нь байв. Нийт эмч нарын 60.6% нарийн мэргэшил эзэмшсэн байв. Шүдний эмч нарт 55.5%-д хүний нөөцийн дутагдалтай байдал, 51.5%-д цалин орлого хангалтгүй, 53.3%-д цагт баригдаж олон хүн үзэх зэрэг хүчин зүйлүүд нь хамгийн их мэргэжлийн стресс үүсгэж байв. Нарийн мэргэшил эзэмшсэн шүдний эмч нар ажлын орчны таагүй байдал болох хүний нөөцийн дутагдалтай байдал (p=0.028), багаар ажиллах чадвар хангалтгүй байх (p=0.004), ажилчидтай хамааралтай асуудлууд (p=0.011) зэрэг хүчин зүйлээс шалтгаалсан стресст илүү өртөж байгаа нь ажиглагдсан. **Дүгнэлт:** Судалгаанд оролцогчдын дунд стрессийг даван туулахад хамгийн түгээмэл ашигладаг арга нь асуудалд эерэг байдлаар дахин хандах (72%) байв. Харин мэргэжлийн стрессээс хамааран ажлын байранд идэвхи санаачлага буурах сөрөг үр дагавар хамгийн (53.9%) түгээмэл тохиолдож байна. Улаанбаатар хотын шүдний эмч нарын дунд орлого санхүү, цаг хугацаатай холбоотой хүчин зүйлүүдэд хамгийн ихээр стресс үүсгэж байна.

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ажлын байран дахь стрессийг 21-р зууны дэлхий даяарх эрүүл мэндийн тахал хэмээн зарласан.[7.10] Тус байгууллагын тодорхойлсноор стресс нь "Хүмүүсийн мэдлэг чадварт үл нийцэх, даван туулах нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх дарамт, шаардлага тулгарахад үзүүлж буй хариу үйлдэл бөгөөд өвчин биш юм"[1] гэж үзжээ. Стресс нь бие махбодын бүх эрхтэн системд нөлөөлж хүмүүсийн мэдрэмж, зан төлөвт өөрчлөлт оруулдаг. Стресс үүсгэгч хүчин зүйлийг стрессор гэж нэрлэх бөгөөд хэрэв хүн стресс үүсгэгч хүчин зүйлийн нөлөөлөлд байнга өртвөл тэдгээрийн хооронд даван туулах хангалттай хугацаа байдаггүйгээс эрүүл мэндэд таагүй нөлөө үзүүлэх архаг стрессийг үүсгэдэг.[2,3] Стресст үзүүлэх хариу урвал нь хувь хүний мэдрэг байдал, бэрхшээлийг даван туулах чадвар арга зам,

ерөнхий биеийн эрүүл мэнд, стресс үүсгэгч хүчин зүйлсийн нөлөөлөл зэргээс хамаарч сэтгэц болон бие махбодын өөрчлөлтөөр илэрч болно гэжээ.[2,4,5] Эмнэлзүйн сүүлийн үеийн судалгаагаар шүдний эмч, мэргэжилтнүүд стрессээс шалтгаалсан маш олон төрлийн бие эрхтэн ба сэтгэлзүйн таагүй нөхцөл байдалд байнга өртөж байдаг нь батлагдсаар байна.[2,6]

Шүдний эмчийн ажлын олон хүчин зүйл стресс үүсэхэд хүргэдэг байна. Эмнэлзүйн нарийн ажилбар, эмчилгээний үр дүнд урам хугарах, үйлчлүүлэгчийн айдас түгшүүр, цаг хугацааны дарамт, мэргэжлийн ур чадвараа сайжруулахын тулд тасралтгүй суралцах шаардлага зэрэг нь стресс үүсгэдэг. Эдгээр нь үйлчлүүлэгч нарт өндөр чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдэнд хүнлэг хандах чадвар эзэмшихийн тулд шүдний эмч бүрт тулгардаг гол бэрхшээлийг илэрхийлэх ерөнхий хүчин зүйлс бөгөөд эмнэлгийн дүрмийг чанд дагаж мөрдөхтэй хосолсон ёсзүйн асуудал болохыг судлаачид онцолсон байна.[7-9] Дэлхийн улс орнуудад шүдний эмч нарын дундах стрессийн түвшинг үнэлэх олон судалгаа хийгдсэн боловч манай улсад энэ төрлийн судалгааны баримт мэдээлэл одоогоор хомс байгаа нь энэхүү судалгааны ажлыг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Шүдний эмч нарын ажил мэргэжилтэй холбоотой стресс үүсгэгч хүчин зүйлсийг тодорхойлох.

Зорилт:

1. Шүдний эмч нарын дунд стресс үүсгэх хүчин зүйлсийг тодорхойлох
2. Стресс үүсгэх хүчин зүйлсийг нас, хүйс, ажилласан жилээр харьцуулан судлах
3. Стрессийг даван туулах арга зам, ажлын байран дээр гарах үр дүнг тодорхойлох

Арга, аргачлал: Бид АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022/3-01 тоот зөвшөөрлийн дагуу Улаанбаатар хотод мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй нийт шүдний эмчийг төлөөлөх чадвар бүхий 324 эмчийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар хийж гүйцэтгэсэн. Хүн ам зүйн мэдээлэл, Купер болон Вадингтон нарын боловсруулсан мэргэжлийн стресс үүсгэгч хүчин зүйл ба стрессийг даван туулах арга, үр нөлөөг үнэлэх 3 бүлэг 42 асуулт бүхий хэвлэмэл асуумж ашиглан судалгааг авч үр дүнг SPSS IBM 25.0 программ ашиглан статистик боловсруулалт хийв.


Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт 289 (89.2%) эмчийн 222 (77%) нь эмэгтэй, 67 (23%) нь эрэгтэй, 60.6% нь нэг ба хэд хэдэн чиглэлээр нарийн мэргэшил эзэмшсэн байв. Нийт эмч нарын 64.4% нь гэр бүлтэй, 69.6% нь хүүхэдтэй байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагсдын хүн ам зүйн үзүүлэлтүүдийг насны бүлгээр харьцуулсан дүн

Үзүүлэлтүүд		Насны бүлэг					Нийт		P утга
		<30	31-40	41-50	51-60	>70	n	%	
Хүйс	Эрэгтэй	29	26	8	3	1	67	23.0%	0.218
	Эмэгтэй	128	70	14	9	1	222	77.0%	
Ажилласан жил	10-с доош	151	41	2	1	0	195	69.6%	0.001
	11-20 жил	2	51	16	0	0	69	23.9%	
	21-30 жил	2	0	4	5	0	11	3.8%	
	31-40 жил	0	0	0	6	1	7	2.4%	
	50-с дээш	0	0	0	0	1	1	0.3%	
Ажилладаг байгууллага	Улсын байгууллага	26	32	6	8	1	73	25.3%	0.001
	Хувийн байгууллага	129	64	13	4	1	211	73.0%	
	Аль алинд нь	2	0	3	0	0	5	1.7%	
7хоногт ажилладаг цаг	*40-с доош*	103	67	12	10	0	192	66.1%	0.507
	40-с дээш	50	27	8	2	0	87	30.5%	
Гэрлэлтийн байдал	*Гэрлээгүй*	72	79	22	11	2	186	32.2%	0.001
	Гэрлэсэн	81	13	0	0	0	94	64.4%	
	Салсан	4	4	0	0	0	8	2.8%	
	Бэлэвсэн	0	0	0	1	0	1	0.3%	
Хүүхэдтэй эсэх	*Тийм*	76	90	21	12	2	201	69.6%	0.001
	Үгүй	81	6	1	0	0	88	30.4%	
Нарийн мэргэшил эзэмшсэн эсэх	*Тийм*	70	78	18	7	2	175	60.6%	0.001
	Үгүй	87	18	4	5	0	114	39.4%	

Мэргэжлийн стресс үүсгэгч хүчин зүйлсийг таван бүлэгт хуваан стрессийн түвшинг багаас маш их хүртэл 1-5 оноогоор дүгнэн дундаж утгыг харьцуулахад орлого, санхүүтэй холбоотой хүчин зүйлс хамгийн их (3.321.29 оноо) стресс үүсгэж байсан бол цаг хугацаатай холбоотой хүчин зүйлс (3.301.27 оноо), үйлчлүүлэгчтэй холбоотой хүчин зүйлс (3.071.2 оноо), ажлын орчин болон бусад хүчин зүйлс (3.11.2 оноо) тус тус байв. Харин мэргэжлийн ур чадвар, арга барилтай холбоотой хүчин зүйлс (2.71.1 оноо) буюу хамгийн бага стресс үүсгэж байгаа нь тодорхойлогдсон.

Шүдний эмч нарын дунд хамгийн их мэргэжлийн стресс үүсгэгч 10 хүчин зүйлийг (их, маш их гэж үнэлсэн) харьцуулан үзэхэд 55.5%-д хүний нөөцийн дутагдалтай байдал, 53.5%-д цагт баригдаж олон хүн үзэх, 51.5%-д цалин орлого бага байх нь стресст өртөх гол хүчин зүйл болж байгаа нь харагдлаа. Гэтэл ажлын байран дах ганцаардах мэдрэмж 56%, ажлын нэг хэвийн давтамжтай хэмнэл 46%, үзлэгийн үед яаралтай тусламж шаардлагатай болох 45% нь хэр их стресс үүсгэдэг вэ? гэсэн асуултуудад эмч нарын ихэнх нь төдийлөн стресс үүсгэдэггүй гэж хариулсан байлаа. (Зураг 1)



Зураг 1. Мэргэжлийн стресс үүсэхэд хамгийн их нөлөөлж буй хүчин зүйлсийг харьцуулсан дүн

Судалгаанд оролцогчдын 72% нь асуудалд эерэг байдлаар дахин хандах аргаар стрессийг даван туулж байхад талаас илүү буюу 63% нь ажилдаа илүү анхаарах, 52.6% стресс бүхий нөхцөл байдлаас зайлсхийх аргуудыг ажлын байрны стрессийг бууруулах даван туулахад ашиглаж байна. Мөн 38-47 хувь нь ажлаас гадуурх хоббигоо хөгжүүлэх бусдаас дэмжлэг авдаг байна. Судалгаанд оролцогчдын цөөн боловч 5% нь эм ууж тайвширч байгаа анхаарахуйц тоо гэж бодож байна. (Зураг 2)



Зураг 2. Стрессийг даван туулах стратегийг харьцуулсан дүн

Эмэгтэй шүдний эмч нарт хэтэрхий өндөр хүлээлттэй, харьцахад хэцүү үйлчлүүлэгч ($p=0.001$), эм тариатай холбоотой хүндрэл гарах ($p=0.002$), багаж хэрэгслийн эвдрэл болон дутагдалтай байдал ($p=0.003$) зэрэг үйлчлүүлэгчтэй холбоотой хэд хэдэн хүчин зүйлс эрэгтэй эмч нараас илүү стресс үүсгэж буй стастикийн ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Стресс үүсгэгч хүчин зүйлсийг хүйсээр харьцуулсан дүн


Стресс үүсгэгсч хүчин зүйл	стрессийн үнэлгээ	Хүйс		Р утга
		Эрэгтэй	Эмэгтэй	
Хэт их айдастай хүн эмчлэх	их	4.8% (14)	18.3% (53)	**0.007**
	бага	4.1% (12)	12.8% (37)	
Өндөр хүлээлттэй,харьцахад хэцүү үйлчлүүлэгч	их	2.7% (8)	23.1% (67)	**0.001**
	бага	4.1% (12)	9.6% (28)	
Үйлчлүүлэгчээс хамаарч эмчилгээний үр дүн муу байх	их	5.1% (15)	17.9% (52)	0.14
	бага	3.8% (11)	16.2% (47)	
Эм тариатай холбоотой хүндрэл гарах	их	3.1% (9)	14.5% (42)	**0.002**
	бага	3.4% (10)	16.6% (48)	
Хуримтлал үүсгэх боломж бага байх	их	3.1% (9)	20.7% (60)	0.043
	бага	2.07% (6)	9.6% (28)	
Албан болон албан бус татварын суутгалт (НДШ гэх мэт)	их	3.1% (9)	23.1% (67)	0.038
	бага	5.1% (15)	8.9% (26)	
Үйлчлүүлэгч эмчилгээний явц, эрсдэл хүндрэлийг ойлгохгүй байх	их	1.3% (4)	17.6% (51)	0.016
	бага	6.9% (20)	20.4% (59)	
Эмчилгээний шинэ арга техникийг хэрэглэх мэдлэг, дадлага дутуу байх	их	3.1% (9)	12.4% (36)	0.01
	бага	2.7% (8)	18.6% (54)	
Багаж хэрэгслийн эвдрэл болон дутагдалтай байдал	их	9.6% (28)	14.1% (41)	**0.003**
	бага	2.07% (60	0.11% (34)	

Стресс үүсгэгч хүчин зүйлүүдийг насны бүлгээр харьцуулахад 20-30 нас болон 31-40 хүртэлх насны бүлгүүдэд бусад насны бүлгээс статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. Эдгээр насны бүлгүүдэд мөн адил цалин орлого бага байх (p=0.001), мэргэжлийн ёс зүй болон орлого санхүүгийн асуудал зөрчилдөх (p=0.001), хуримтлал үүсгэх боломж бага байх (p=0.001) гэсэн санхүүтэй холбоотой хүчин зүйлс хамгийн их стресс үүсэхэд давамгайлж байлаа. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Стресс үүсгэгч хүчин зүйлсийг насаар харьцуулсан дүн

Стресс үүсгэгсч хүчин зүйл	Стрессийн үнэлгээ	Нас		Р утга
		21-30 нас	31- 40 нас	
Эм тариатай холбоотой хүндрэл гарах	их	9.3% (27)	4.8% (14)	**0.001**
	бага	12.1% (35)	5.9% (17)	
Байнга олон цагаар ажиллах	их	14.2% (41)	6.6% (19)	**0.002**
	бага	8.7% (25)	8.3% (24)	
Үзлэг хооронд амралтгүйгээр ажиллах	их	17% (49)	8.3% (24)	**0.007**
	бага	8.7% (25)	3.8% (11)	
Цалин бага байх	их	18% (52)	2.8% (8)	**0.001**
	бага	4.8% (14)	5.2% (15)	
Мэргэжлийн ёс зүй болон орлого санхүүгийн асуудал зөрчилдөх	их	13.1% (38)	4.5% (13)	**0.001**
	бага	4.2% (12)	5.5% (16)	
Хуримтлал үүсгэх боломж бага байх	их	16.6% (48)	5.9% (17)	**0.001**
	бага	3.1% (9)	5.2% (15)	
Үйлчлүүлэгч эмчилгээний явц, эрсдэл хүндрэлийг ойлгохгүй байх	их	13.5% (39)	4.2% (12)	0.014
	бага	11.8% (34)	9.7% (28)	
Үйлчлүүлэгчийн зовиур	их	11.1% (32)	3.8% (11)	0.03
	бага	13.5% (39)	7.3% (21)	
Халдварт өртөх эрсдэл	их	15.9% (46)	10.7% (31)	**0.002**
	бага	11.1% (32)	5.2% (15)	
Багаар ажиллах чадвар хангалтгүй байх	их	19.4% (56)	6.9% (20)	0.026
	бага	8.3% (24)	4.8% (14)	

Мэргэжлийн стресээс хамааран ажлын байранд идэвх санаачлага буурах үзэгдлийг тодруулахад 53.9%-д, ажлын бүтээмж багасах 51.9%, анхаарал төвлөрөх чадвар бууралт 44.3% байх зэрэг сөрөг үр дагавар хамгийн түгээмэл тохиолдож байна. (Зураг 3)



Зураг 3. Мэргэжлийн стресстэй холбоотой ажлын байранд гарах үр дагаврыг харьцуулсан дүн

Хэлцэмж: Бидний судалгаанд оролцогчдын дунд ажил мэргэжилтэй холбоотой стресс хамгийн их үүсгэж буй хүчин зүйлс нь үйлчлүүлэгч болон цаг хугацаа, цалин орлоготой холбоотой байв. Энэхүү дүн бусад судлаач нарын судалгааны үр дүнтэй ойролцоо байлаа. Тухайлбал Choy H (2017) нарын Хонг Конгийн шүдний эмч нарын дундах мэргэжлийн стресс, ажлаас халшрах хам шинжийг судалсан судалгаанд хамгийн их стресс үүсгэгч 10 хүчин зүйлийн 6-д үйлчлүүлэгч, цаг хугацаатай холбоотой байв.[12]

Kyung W (2019) нарын Өмнөд Солонгос улсын эмч нарын мэргэжлийн стресс, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судалсан судалгаанд шүдний эмч нарын дунд стресс үүсэхэд орлого санхүү (p=0.023), ажлын цаг хугацаатай (p=0.0009) холбоотой хүчин зүйлс ихэвчлэн нөлөөлж байгааг онцолсон.[15] Гадаадын улс орны судалгаануудад стресс үүсгэгч гол хүчин зүйл нь үйлчлүүлэгч, цаг хугацаатай холбоотой байхад манай орны хувьд орлого, санхүүгийн хүчин зүйлс (p=0.001) давамгайлж байсан нь нийгэм, эдийн засгийн байдал, иргэдийн амьдралын чанар, эрүүл мэндийн боловсролын дутмаг байдалтай хамааралтай байх магадлалтай юм.

Судалгаанд хамрагдсан шүдний эмч нарын ихэнх хувийг 40-өөс доош насны залуу эмч нар (n=195; 69.6%) эзэлж байгаа өмнө хийгдсэн бусад орны судалгааны үзүүлэлттэй ойролцоо[14-16] байсан ба нарийн мэргэшил эзэмшсэн эмч нарт (n=175; 60.6%) нарийн мэргэшил эзэмшээгүй эмч нараас илүү төрийн байгууллагын дарамт, хэт их шаардлагатай бичиг баримт (p=0.001), багаар ажиллах чадвар хангалттүй байх (p=0.004) зэрэг мэргэжлийн бус ажлын орчин болон бусад хүчин зүйлүүд стресс үүсгэж байгаа нь статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байв. Залуу эмч нарт ажлын туршлага, ур чадварын дутмаг байдлаас хамаарч мэргэжил болон үйлчлүүлэгчтэй холбоотой хүчин зүйлс илүү стресс үүсгэж байна гэж үзэж байна.

Van Nhat Thang Le (2021) нарын шүдний эмч нарын ажилдаа сэтгэл хангалуун байдлыг тодорхойлсон судалгаагаар 76.6% нь дунд болон түүнээс дээш түвшинд байсан ба хамгийн их сэтгэл ханамж авдаг хүчин зүйлс нь үйлчлүүлэгч эмч хоорондын харилцаа, хүндэтгэл, эрүүл мэндийн тусламж хүргэх, эмч болон ажилчидын хамтын ажиллагаа, мэргэжлийн орчин гэж дүгнэсэн бол сэтгэл ханамжгүй байдаг хүчин зүйлүүдэд чөлөөт цаг бага байх, стресс, орлого, олон цагаар ажиллах, мэргэжлийн ур чадварын менежмент зэрэг багтсан байна.[17] Гэсэн хэдий ч энэхүү мета-судалгаануудын үр дүн нь амьдралын чанар сайн, өндөр орлоготой орнуудад хийгдсэн байсан нь бидний судалгаанаас ялгаатай байлаа.

Манай шүдний эмч нарын стрессийг даван туулах түүнээмэл арга нь Wong MC. (2001), Choy H (2017) нарын ижил төстэй судалгаануудын үр дүнтэй ижил буюу ихэнхдээ стресс бүхий нөхцөл байдлыг хянах, асуудалд ахин эерэгээр хандах зэрэг хувь хүн руу чиглэсэн аргуудыг ашиглан шийдвэрлэж байгаа нь шүдний эмч нарын бие даан ажилладаг мэргэжлийн онцлог чадвартай холбоотой гэж үзэж байна.[12,18]

Дүгнэлт:

1. Улаанбаатар хотод мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй шүдний эмч нарын дунд хамгийн түгээмэл стресс үүсгэгч бүлэг хүчин зүйл нь цаг хугацаа, орлого санхүүтэй холбоотой байсан бөгөөд ажлын туршлага бага залуу эмч нар ажил мэргэжилтэй холбоотой хүчин зүйлүүдэд илүү стрессд өртөж байна.
2. Нарийн мэргэшил эзэмшсэн туршлагатай эмч нарын хувьд ажлын орчны таагүй уур амьсгал, багаар ажиллах байдал дутмаг байгаа, хүний нөөцийн дутагдалтай байдал илүү стресс үүсэхэд нөлөөлж байна.
3. Ажил мэргэжилтэй холбоотой стрессд өртөснөөр ихэнхдээ ажлын байран дээрх идэвхи санаачлага буурах, ажлын бүтээмж багасах шинж тэмдгүүд ажиглагдсан бөгөөд эдгээр нь урт хугацаанд үргэлжилснээр ажлаас халшрах эрсдэлд хүргэж болзошгүй байна.

Ном зүй:

1. *Work Related Stress, https://www.deakin.edu.au/students/health-and-wellbeing/occupational-health-and-safety/ work-related-stress.*
2. *Knezevic B, Milosevic M, Golubic R, Belosevic L, Russo A, Mustajbegovic J. Work-related stress and work ability among Croatian university hospital midwives. Midwifery. 2011 Apr;27(2):146-53.*
3. *Pejcic N, Jovicic MD, Miljkovic N, Popovic DB, Petrovic V. Posture in den- tists: Sitting vs. standing positions during dentistry work--An EMG study. Srp Arh Celok Lek. 2016 Mar-Apr;144(3-4):181-7.*
4. *McCunney RJ. Psychiatric Aspects of Occupational Medicine. In: McCun- ney RJ (Ed).A Practical Approach to Occupational and Enviromental Medicine. Boston: Little, Brown and Company;*

1994. p. 267-71.
5. Pavicevic L, Bobic J, Stress at work. In: Saric M, Zuskin E- editors. La- bor Medicine and the Environment. Medical Publishing: Zagreb; 2002. p. 530-537.
6. Muhic E, Plancak D, Lajnert V, Muhic A. Predictors of Job Satisfaction in Dental Professionals of the Bosnia and Herzegovina Federation. Acta Stomatol Croat. 2016 Sep;50(3):222-229.
7. Pejcic N, Petrovic V, Dimitrijevic I, Markovic D. Stress caused by work in the dental profession. Stom. 2018 Mar; 24 (1):59-64.
8. Moore R, Brodsgaard I. Dentists' perceived stress and its relation to perceptions about anxious patient. Community Dent Oral Epi-demiol. 2001 Feb;29(1):73-80.
9. Cooper C, Watts J, Kelly M. Job satisfaction, mental health and job stressors among general dental practitioners in the UK. Br Dent J.1987 Jan;162(2):77-81.
10. National Research Council (NRC), Institute of Medicine IOM. Musculo- skeletal Disorders and the Workplace: Low Back Pain and Upper Extremi- ties. Washington, DC; 2001.
11. Collin V, Toon M, O'Selmo E, Reynolds L, Whitehead P. A survey of stress, burnout and well-being in UK dentists. BDJ, 2019;226:40.
12. Choy, HB; Wong, MCM. Occupational stress and burnout among Hong Kong dentists . Hong Kong Medical Journal, 2017, v. 23, p. 1-9
13. Waddington TJ. New stressors for GDPs in the past 10 years. Br Dent J 1997;182:82-3
14. Myoung-Uk Jin, Seong-Hwa Jeong, Eun-Kyong Kim, Youn-Hee Choi, Keun-Bae Song, Burnout and its related factors in Korean dentists,International Dental Journal, Volume 65, Issue 1, 2015, Pages 22-31,
15. Kyung-Won Song, Hye-Kyoung Kim, Job stress and its related factors among Korean dentists: An online survey study, International Dental Journal, Volume 69, Issue 6, 2019, Pages 436-444,
16. Chen-Yi Lee, Ju-Hui Wu, Je-Kang Du, Work stress and occupational burnout among dental staff in a medical center,Journal of Dental Sciences, Volume 14, Issue 3,2019,Pages 295-301,ISSN 1991-7902,
17. Van Nhat Thang Le, Minh-Huy Dang, Jae-Gon Kim, Yeon-Mi Yang, Dae-Woo Lee, Dentist Job Satisfaction: A Systematic Review and Meta-analysis, International Dental Journal, Volume 71, Issue 5, 2021, Pages 369-377
18. Wong MC, Ng KK, Tang AK, Tang GC, Lam VN. Occupational stress among dental practitioners in Hong Kong. Hong Kong Dent Assoc Millennium Rep 2001;II:50- 5.

Assessment of occupational stressors among dentists

Sainzaya G[1], Batjargal Ch[1],Soyolmaa M[1], Urjinlkham J[1]

[1]Department of Restorative Dentistry, School of Dentistry, MNUMS
[2]Coraldent dental hospital
E-mail: zayags.724@gmail.com, Tel: +976-99121908

Background: The World Health Organization has declared stress in the workplace as the worldwide health epidemic of the 21th century. Almost half of dentists say stress in their job is exceeding their ability to cope and the most stressful aspects of their work are related to regulation and fear of litigation from patients, according to a new large scale study published in this issue of *BDJ, 2019*. The consequences of dissatisfaction in the workplace are reflected in frequent sick leave, errors at work, professional burnout, job abandonment, reduced satisfaction of the healthcare service recipient, and the reduced quality of mental health in doctors. According to worldwide there are many studies of occupational stress of dentists, but there is no study about this issue in our country. In accordance this above we aimed to conduct this study.
Aim: This study was aimed to evaluate occupational stressors among Mongolian dentist.
Materials and Methods: This study was comprised 289 dentists. The study sample was selected by purposive sampling model, and we used cross-sectional method. Study questionnaire assessed occupational stressors and stress coping strategies, effects of stress and social demographic characteristics of the responders. SPSS program used for statistical analysis.
Results: Out of 289 dentists, 222 (77%) were women and 67 (23%) were men. 60.6% of dentists have specialized qualifications. Among dentists, the highest occupational stressors were lack of human resources, insufficient salary and risk of infection. It was found that dentists with advanced qualifications were more stressed by the work environment and other factors (p=0.028). The most common method used by respondents to cope with stress was re-approaching the problem in a positive way (72%). However, depending on professional stress, the most common adverse effect is the decrease in initiative in the workplace (53.9%).
Conclusion: Among dentists in Ulaanbaatar city, the highest professional stressors are related to income and time.

Keywords: Patient, Burnout, Stress, Time pressure